



МОНГОЛ УЛС
САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ
ТОГТООЛ

2013 оны 11 сарын 06 өдөр

Дугаар 417

Улаанбаатар хот

“Хэрэглээ импекс” ХК-ийн үнэт цаасыг
бүртгэлээс хасах тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6.1.1, 6.2.2, Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 34.1.1, Компанийн тухай хуулийн 23 дугаар зүйл, Санхүүгийн зохицуулах хорооны 2009 оны 38 дугаар тогтоолоор батлагдсан “Нийтэд санал болгон худалдах үнэт цаасыг бүртгэх, анхдагч зах зээлд санал болгох, худалдах тухай журам”-ын 8.1 дэх заалтыг тус тус үндэслэн Санхүүгийн зохицуулах хорооноос ТОГТООХ нь:

1. “Хэрэглээ импекс” ХК-ийн нийтэд санал болгон гаргасан нийт 53,000 /тавин гурван мянга/ ширхэг хувьцааг үнэт цаасны бүртгэлээс хасахыг Үнэт цаасны газар /Б.Саруул/, Хөрөнгийн биржийн жагсаалтаас хасахыг “Монголын хөрөнгийн бирж” ХК /Х.Алтай/, Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн бүртгэлээс хасахыг “ҮЦТТХТ” ХХК /Т.Гандулам/-д тус тус үүрэг болгосугай.

2. Компанийн тухай хуулийн 24.1, 53.1 дэх заалтын дагуу өөрийн эзэмшиж байгаа хувьцааг компанид эргүүлэн авахыг шаардах эрх үүссэн хувьцаа эзэмшигчдэд шаардах эрх үүссэн тухай болон уг эрхийг хэрэгжүүлэх журмын талаарх мэдэгдлийг энэхүү тогтоол батлагдсан өдрөөс хойш ажлын 3 хоногт багтаан өдөр тутмын хэвлэл, мэдээллийн хэрэгслээр дамжуулан мэдээлэх, уг мэдээлэлд эрх үүссэн хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалтыг тусгахыг “Хэрэглээ импекс” ХК /Б.Энхтөгс/-д үүрэг болгосугай.

3. Шаардах эрхээ хэрэгжүүлээгүй хувьцаа эзэмшигч түүний дансанд байршуулсан ногдол хувийн мөнгөн хөрөнгийг авалгүйгээр хаалттай компанийн хувьцаа эзэмшигчээр үлдэх хүсэлтийг хэдийд ч гаргаж болохыг тэмдэглэсүгэй.

4. Тус компани хэлбэрээ өөрчилж, үнэт цаасны бүртгэлээс хасагдаж байгаатай холбогдуулан “Хэрэглээ импекс” ХК /Б.Энхтөгс/, “ҮЦТТХТ” ХХК /Т.Гандулам/-д дараах арга хэмжээ авч хэрэгжүүлэхийг үүрэг болгосугай:

1/ Хувьцаагаа компанид эргүүлэн худалдан авахыг шаардах эрх үүссэн хувьцаа эзэмшигчдийн эзэмшилд байгаа хувьцаанд оногдох ногдол хувийн мөнгөн хөрөнгийг нэгж хувьцаанд 3,823 /гурван мянга найман зуун хорин гурав/ төгрөгөөр тооцон “ҮЦТТХТ” ХХК-д гэрээ байгуулан төвлөрүүлж, хувьцаа эзэмшигчдийн шаардах эрхийг хэрэгжүүлэх нөхцлийг хангах;

2/ Хувьцаа эзэмшигч өөрийн эзэмшиж буй хувьцааг компанид эргүүлэн худалдан авах шаардлагыг гаргасан тохиолдолд зохих журмын дагуу нэгж хувьцаанд оногдох ногдол хувийн мөнгөн хөрөнгийг хувьцаа эзэмшигчдэд шуурхай олгох;

3/ Ногдол хувийн мөнгөн хөрөнгийг төвлөрсөн хадгаламж дахь дансанд байршуулахдаа хувьцаагаа компанид эргүүлэн худалдан авахыг шаардах эрх тухайн дансны эзэмшигчид үүссэн тухай тэмдэглэл хийж, харилцагч дансны хуулга авах тухай бүрд зохих тайлбарыг өгч ажиллах;

4/ Энэхүү тогтоолын 4.2-т заасан хүсэлтийг гаргасан тохиолдолд компанийн эзэмшил дэх хувьцаанаас хүсэлт гаргасан хувьцаа эзэмшигчид эзэмшүүлж, түүний хариуд уг хувьцаа эзэмшигчийн төвлөрсөн хадгаламжийн байгууллага дахь дансанд нь байршуулсан ногдол хувийн мөнгөн хөрөнгийг тус компанид шилжүүлж ажиллах.

5. Энэ тогтоол батлагдсанаас хойш ажлын 10 хоногийн дотор Улсын бүртгэлийн ерөнхий газарт мэдээлэл хүргэх, тогтоолын биелэлтэд хяналт тавьж, олон нийтэд мэдээлэхийг Ажлын алба /Х.Бум-Эрдэнэ/-нд даалгасугай.

ДАРГА



Д.БАЯРСАЙХАН